



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/98/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠕.᠒5 № 86
танай _____-ны № _____-т

ХАЙРХАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ш.ДЭЛГЭРЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,991,130.12	84,835,613.99
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ		24,490,892.85
3	Банкинд байгаа бэлэн мөнгө		24,490,892.85
4	Төгрөг		24,490,892.85
5	Төрийн сангийн харилцах		21,609,202.85
6	Нэмэлт санхүүжилтийн харилцах		2,881,690
7	АВЛАГА	899,349.91	119,649
8	Ажиллагчидтай холбогдсон авлага	779,700.91	
9	Бусад авлага	119,649	119,649
10	Байгууллагаас авах авлага	33,000	33,000
11	Хувь хүмүүсээс авах авлага	86,649	86,649
12	БАРАА МАТЕРИАЛ	40,091,780.21	60,225,072.14
13	Түүхий эд материал	17,362,894.21	36,860,799.14
14	Тусгай зориулалттай материал	3,649,050	3,649,050
15	Эм боох материал	13,713,844.21	33,211,749.14
16	Хангамжийн материал	21,573,886	23,364,273
17	Бичиг хэргийн материал	744,300	792,300
18	Аж ахуйн материал	18,968,325	20,968,325
19	Барилгын засварын материал	335,600	335,600
20	Хүнсний материал	1,255,661	998,048
21	Бусад хангамжийн материал	270,000	270,000
22	Мал амьтад	1,155,000	
23	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	439,983,037.84	436,117,216.12
24	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	439,983,037.84	436,117,216.12
25	Биет хөрөнгө	426,947,037.84	423,081,216.12
26	Барилга, байгууламж, орон сууц	308,494,646	308,494,646
27	Хуримтлагдсан элэгдэл	-55,459,424.48	-73,904,984.68
28	Авто-тээврийн хэрэгсэл	62,244,772	48,176,994
29	Хуримтлагдсан элэгдэл	-28,291,049.18	-19,948,965.14
30	Машин тоног төхөөрөмж(компьютер)	340,103,806.81	386,439,786.45
31	Хуримтлагдсан элэгдэл	-215,245,533.83	-240,554,563.18
32	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,891,293.39	17,589,020.12
33	Хуримтлагдсан элэгдэл	-14,268,638.85	-13,687,883.43
34	Бусад үндсэн хөрөнгө	14,244,284	14,244,284
35	Хуримтлагдсан элэгдэл	-3,767,118.02	-3,767,118.02
36	Биет бус хөрөнгө	13,036,000	13,036,000
37	Програм хангамж	762,000	762,000
38	Хуримтлагдсан элэгдэл	-522,000	-522,000
39	Бусад биет бус хөрөнгө	12,796,000	12,796,000
40	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	480,974,167.96	520,952,830.11
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР	147,080	147,080
42	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	147,080	147,080
43	Өглөг	147,080	147,080
44	Бусад өглөг	147,080	147,080
45	Байгууллагад төлөх өглөг	147,080	147,080
46	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	480,827,087.96	520,805,750.11
47	Засгийн газрын хувь оролцоо	480,827,087.96	520,805,750.11
48	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	229,127,433.2	229,127,433.2
49	Хуримтлагдсан үр дүн	19,278,939.58	59,257,601.73

50	Өмнөх үеийн үр дүн	69,256,833.78	19,278,939.58
51	Тайлант үеийн үр дүн		39,978,662.15
52	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,420,715.18	232,420,715.18
53	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	480,974,167.96	520,952,830.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	495,126,081.41	993,452,912.8
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,569,496.41	271,387,635.3
3	Нийтлэг татварын бус орлого	51,569,496.41	271,387,635.3
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,155,000	
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,155,000	
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,379,730	12,806,285.7
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38,034,766.41	258,581,349.6
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443,556,585	722,065,277.5
9	Улсын төвлөрсөн төсвөөс	364,049,000	410,945,500
10	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,049,000	410,945,500
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,688,100	241,338,300
12	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	103,100	34,200,000
13	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,585,000	207,138,300
14	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,618,100	39,950,000
15	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,618,100	39,950,000
16	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	39,201,385	29,831,477.5
17	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,201,385	29,831,477.5
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	545,103,975.61	953,474,250.65
19	УРСГАЛ ЗАРДАЛ	545,103,975.61	953,474,250.65
20	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,411,945.61	919,274,250.65
21	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,411,943.37	394,968,393.49
22	Үндсэн цалин	189,823,296.37	346,929,880.89
23	Нэмэгдэл	85,900,000	14,528,491
24	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000	
25	Урамшуулал	18,088,647	33,510,021.6
26	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,072,899.72	51,768,199.07
27	Тэтгэврийн даатгал	25,739,768.83	36,499,519.21
28	Тэтгэмжийн даатгал	3,028,207.92	3,888,624.97
29	ҮОМШӨ-ний даатгал	2,422,566.12	3,110,899.97
30	Ажилгүйдлийн даатгал	605,641.92	743,442.34
31	Эрүүл мэндийн даатгал	5,276,714.93	7,525,712.58
32	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,014,000	38,098,063
33	Гэрэл, цахилгаан	2,318,300	2,248,816
34	Түлш, халаалт	34,545,700	35,699,247
35	Цэвэр, бохир ус	150,000	150,000
36	Хангамж, бараа материалын зардал	18,795,000	31,418,980
37	Бичиг хэрэг	2,273,600	2,230,150
38	Тээвэр, шатахуун	10,955,800	21,336,730
39	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800	1,306,800
40	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	677,200	5,547,300
41	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,016,600	998,000
42	Бараа материал акталсны зардал	1,565,000	
43	Нормативт зардал	51,892,306.76	329,141,557.67

Хайрхан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

44	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,507,468.76	316,001,044.67
45	Хоол, хүнс	3,734,838	13,020,513
46	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,000	120,000
47	Эд хогшил, урсгал засварын зардал	1,345,000	6,979,900
48	Багаж, техник, хэрэгсэл		1,209,900
49	Урсгал засвар	1,345,000	5,770,000
50	Томилолт, зочны зардал	1,460,500	698,000
51	Дотоод албан томилолт	1,460,500	698,000
52	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,416,538	656,950
53	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,068,008	
54	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	250,000
55	Даатгалын үйлчилгээ	38,530	54,450
56	Тээврийн хэрэгслийн татвар	60,000	33,000
57	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		319,500
58	Бараа үйлчилгээний бусад зардал	76,003,757.76	65,544,207.42
59	Бараа үйлчилгээний бусад зардал	9,107,800	10,277,100
60	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,895,957.76	55,267,107.42
61	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,692,030	34,200,000
62	Бусад урсгал шилжүүлэг		34,200,000
63	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		34,200,000
64	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,692,030	
65	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,692,030	
66	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-49,977,894.2	39,978,662.15
67	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-49,977,894.2	39,978,662.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	69,256,833.78	530,804,982.16
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	69,256,833.78	530,804,982.16
3	Тайлант үеийн үр дүн			-49,977,894.2	-49,977,894.2
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	19,278,939.58	480,827,087.96
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	19,278,939.58	480,827,087.96
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	19,278,939.58	480,827,087.96
7	Тайлант үеийн үр дүн			39,978,662.15	39,978,662.15
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	229,127,433.2	232,420,715.18	59,257,601.73	520,805,750.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	443,556,585	722,065,277.5
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443,556,585	722,065,277.5
3	Улсын төвлөрсөн төсвөөс	364,049,000	410,945,500
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,049,000	410,945,500
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,688,100	241,338,300
6	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	103,100	34,200,000
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,585,000	207,138,300
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,618,100	39,950,000
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,618,100	39,950,000
10	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	39,201,385	29,831,477.5
11	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,201,385	29,831,477.5
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	443,556,585	658,979,384.65
13	УРСГАЛ ЗАРДАЛ	443,556,585	658,979,384.65
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,864,555	624,779,384.65
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,349,086	396,840,296.65
16	Үндсэн цалин	183,500,000	183,500,000
17	Нэмэгдэл	85,900,000	169,820,937.65
18	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000	
19	Урамшуулал	18,349,086	33,041,402
20	Гэрээт ажлын хөлс		10,477,957
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,560,991	49,116,595
22	Тэтгэврийн даатгал	26,966,208	36,866,415
23	Тэтгэмжийн даатгал	2,893,190	3,168,940.8
24	ҮОМШӨ-ний даатгал	2,317,970	2,477,372.83
25	Ажилгүйдлийн даатгал	588,698	605,623.03
26	Эрүүл мэндийн даатгал	5,794,925	5,998,243.34
27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,014,000	38,098,063
28	Гэрэл, цахилгаан	2,318,300	2,248,816
29	Түлш, халаалт	34,545,700	35,699,247
30	Цэвэр, бохир ус	150,000	150,000
31	Хангамж, бараа материалын зардал	15,542,600	30,105,980
32	Бичиг хэрэг	2,300,000	1,911,650
33	Тээвэр, шатахуун	9,885,800	21,612,230
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800	1,306,800
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000	1,783,300
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,550,000	3,492,000
37	Нормативт зардал	20,835,253	91,601,500
38	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,213,338	71,481,500
39	Хоол, хүнс	3,971,915	17,620,000
40	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,000	2,500,000
41	Эд хогшил, урсгал засварын зардал	1,422,400	8,232,400
42	Багаж, техник, хэрэгсэл		1,872,400
43	Урсгал засвар	1,422,400	6,360,000
44	Томилолт, зочны зардал	1,460,500	698,000
45	Дотоод албан томилолт	1,460,500	698,000
46	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,623,925	1,087,450
47	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,275,395	
48	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	250,000
49	Даатгалын үйлчилгээ	38,530	54,450
50	Тээврийн хэрэгслийн татвар	60,000	33,000
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		750,000
52	Бараа үйлчилгээний бусад зардал	8,055,800	8,999,100
53	Бараа үйлчилгээний бусад зардал	8,055,800	8,999,100

Хайрхан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

54	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,692,030	34,200,000
55	Бусад урсгал шилжүүлэг		34,200,000
56	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		34,200,000
57	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,692,030	
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,692,030	
59	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		63,085,892.85
60	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		38,595,000
61	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		38,595,000
62	Дотоод эх үүсвэрээр		38,595,000
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		38,595,000
64	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-38,595,000
65	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		24,490,892.85
66	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,490,892.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	490,097,700	459,117,774.65	30,979,925.35	93.68
2	УРСГАЛ ЗАРДАЛ	490,097,700	459,117,774.65	30,979,925.35	93.68
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,097,700	459,117,774.65	30,979,925.35	93.68
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,908,200	316,487,066.65	10,421,133.35	96.81
5	Үндсэн цалин	183,500,000	183,500,000	0.00	100.00
6	Нэмэгдэл	96,500,000	89,467,707.65	7,032,292.35	92.71
7	Урамшуулал	35,014,000	33,041,402	1,972,598.00	94.37
8	Гэрээт ажлын хөлс	11,894,200	10,477,957	1,416,243.00	88.09
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,132,700	41,616,595	2,516,105.00	94.30
10	Тэтгэврийн даатгал	31,056,300	29,366,415	1,689,885.00	94.56
11	Тэтгэмжийн даатгал	3,269,100	3,168,940.80	100,159.20	96.94
12	ҮОМШӨ-ний даатгал	2,615,300	2,477,372.83	137,927.17	94.73
13	Ажилгүйдлийн даатгал	653,800	605,623.03	48,176.97	92.63
14	Эрүүл мэндийн даатгал	6,538,200	5,998,243.34	539,956.66	91.74
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,350,000	38,098,063	251,937.00	99.34
16	Гэрэл, цахилгаан	2,500,000	2,248,816	251,184.00	89.95
17	Түлш, халаалт	35,700,000	35,699,247	753.00	100.00
18	Цэвэр, бохир ус	150,000	150,000	0.00	100.00
19	Хангамж, бараа материалын зардал	28,106,800	15,321,600	12,785,200.00	54.51
20	Бичиг хэрэг	2,300,000	1,911,650	388,350.00	83.12
21	Тээвэр, шатахуун	19,450,000	7,473,650	11,976,350.00	38.42
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800	1,306,800	0.00	100.00
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000	1,137,500	362,500.00	75.83
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,550,000	3,492,000	58,000.00	98.37
25	Нормативт зардал	34,000,000	34,000,000	0.00	100.00
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,000,000	24,000,000	0.00	100.00
27	Хоол, хүнс	7,500,000	7,500,000	0.00	100.00
28	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000	2,500,000	0.00	100.00
29	Эд хогшил, урсгал засварын зардал	5,100,000	2,809,900	2,290,100.00	55.10
30	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000	1,209,900	2,290,100.00	34.57
31	Урсгал засвар	1,600,000	1,600,000	0.00	100.00
32	Томилот, зочны зардал	3,300,000	698,000	2,602,000.00	21.15
33	Дотоод албан томилот	3,300,000	698,000	2,602,000.00	21.15
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000	1,087,450	112,550.00	90.62
35	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	250,000	0.00	100.00
36	Даатгалын үйлчилгээ	80,000	54,450	25,550.00	68.06
37	Тээврийн хэрэгслийн татвар	120,000	33,000	87,000.00	27.50
38	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	750,000	750,000	0.00	100.00
39	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000	8,999,100	900.00	99.99
40	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000	8,999,100	900.00	99.99
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	490,097,700	480,726,977.50	9,370,722.50	98.09
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	410,945,500	410,945,500	0.00	100.00
43	Улсын төсвөөс санхүүжих			0.00	
44	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,945,500	410,945,500	0.00	100.00

Хайрхан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

45	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,950,000	39,950,000	0.00	100.00
46	Орон нутгийн төсвөөс	39,950,000	39,950,000	0.00	100.00
47	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,202,200	29,831,477.50	9,370,722.50	76.10
48	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,202,200	29,831,477.50	9,370,722.50	76.10
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,609,202.85	-21,609,202.85	
51	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
52	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
53	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0.00	100.00
54	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
55	Гүйцэтгэх ажилтан	19	19	0.00	100.00
56	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
57	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	0.00	100.00
58	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	19	0.00	100.00
59	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,466,610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,466,610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,266,610.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,353,230.00
210102	Нэмэгдэл	80,353,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,500,000.00
210201	Тэтгэврийн даатгал	7,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,784,380.00
210402	Тээвэр, шатахуун	14,138,580.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,800.00
2105	Нормативт зардал	57,601,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,481,500.00
210502	Хоол, хүнс	10,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,027,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,267,500.00
210604	Урсгал засвар	4,760,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,338,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,338,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,138,300.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,881,690.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хайрхан сумын ЭМТ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хайрхан сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах”, 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх”, 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “*Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд цогцоор нь чанартай хүргэх*” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/585 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхан сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 490.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 15.5 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0.90	0.12	(0.78)	(655.46)
Бараа материал	40.09	60.23	20.13	33.43
Үндсэн хөрөнгө	439.98	436.12	(3.87)	(0.89)
Нийт хөрөнгө	480.97	496.46	15.49	3.12
Өр төлбөр	0.15	0.15	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	480.83	520.81	39.98	7.68
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	480.97	520.95	39.98	7.67

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 0.78 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын данс нь 0.89 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлага 0.78 сая төгрөгөөр буурч оны эцэст 0.12 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэл 33.4 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 40.09 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 119.2 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 258.6 сая төгрөг нийт 377.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 357.7 сая төгрөгийн зарцуулалт гарч, 60.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 0.9 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 439.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 38.6 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 12.8 сая төгрөг нийт 51.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 55.3 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 436.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөрийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. 0.05 сая төгрөг байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлттэй холбоотойгоор 0.05 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 39.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт / төгрөгөөр/
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт - /эрүүл мэндийн даатгалын сангаас/	39.20	29.83	(9.37)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт - /улсын төсөв/	364.05	410.95	46.90
Нэмэлт санхүүжилтийн орлого	1.69	241.34	239.65
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12.38	12.81	0.43
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38.03	258.58	220.55
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсвөөс/	38.62	39.95	1.33
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1.16	-	(1.16)
Үйл ажиллагааны орлого	495.12	993.45	498.33
Цалин, шимтгэлийн зардал	337.48	446.74	109.25
Бусад бараа үйлчилгээний зардал	190.93	472.54	281.62
Урсгал шилжүүлэг	16.69	34.20	17.51
Үйл ажиллагааны зардал	545.10	953.48	408.38
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	-	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(49.98)	39.97	89.95

Хайрхан сумын ЭМТ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 38.8 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн нь ковид 19 холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч, дархлаажуулалт, пср, пср-ийн зөөвөр, урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн цогц үйлчилгээ авагч даатгуулагчийн тусламж үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 587.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 97.4 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 490.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 490.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг 93.6 хувь буюу 459.1 сая төгрөгийг авч, бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМГ-аас 34.2 сая төгрөг, аймгийн ИТХ-аас 2.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас ковид 19 цар тахалтай холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч болон дархлаажуулалтаар 201.6 сая төгрөг нийт 238.4 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд ковид 19 цар тахалтай холбоотой 300 даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, 5941 даатгуулагчид дархлаажуулах вакцины үйлчилгээг тус тус үзүүлсний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 201.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх журмын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-аас хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат худалдан авахад 2.6 сая санхүүжилт олгосонг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ЭМГ-аас Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/496, А/585 тушаалын дагуу нэгдсэн эмнэлгийн 25 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зориулж 34.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2 давхар 2273 м2 талбайтай шинэ барилга нь Эрүүл мэндийн Сайдын багцаас 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр анх 2019 оноос 2021 оны 11 сар хүртэл 3 жилийн хугацаанд баригдаж, зарим ажлын гүйцэтгэл дутуу гэсэн үндэслэлээр барилга байгууламж ашиглалтанд оруулах улсын комисс хүлээж аваагүй тул 2021 оны тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Гэтэл 2022 оны 01 сард эрүүл мэндийн төвийн албан хаагчид шинэ байранд шилжин орсон нөхцөл байдал ажиглагдлаа.

Хайрхан сумын ЭМТ нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 3122 иргэнд ПСР-ийн шинжилгээг, 7869 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 5941 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 512 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 17444 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 84.2 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 490.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 93.7 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор иргэнээс 0.68 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн материал хандиваар орж ирсэнг бүртгэл тайланд тусгасан байна.
2. Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд 21.3 сая төгрөгийн шатахуун, 5.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 2 жолоочтой, жолоочийн цалинд 12.4 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хайрхан сумын ЭМТ нь 2021 онд нийт 1,291.2 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,259.8 сая төгрөгийн 100 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан байна. 31.4 сая төгрөгийн 51 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй, зарим албан хаагчдын НДШ-ийг зөрүүтэй тооцсон зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, шимтгэлийг үнэн зөв тооцож ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснээс НДШ-ийг зөрүүгүй тооцож хэрэгжилтийг хангасан харин дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасанд аудитаар албан шаардлага хүргүүллээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 127.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.2 сая төгрөгийн алдааг залруулж, 31.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 86.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 9.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

1. 2001 онд үүссэн 18 жилийн насжилттай 0.1 сая төрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант жилд үйлдвэрчний эвлэлийн 0.1 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, авлага, өр төлбөрийг барагдуулах албан шаардлагыг хүргүүлэх

2. Тус байгууллага нь 2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 -д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлага хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 185 нэр төрлийн 86.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Хайрхан ЭМТ	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 9.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.	1	9.2	1	9.2						
2		2001 онд үүссэн 18 жилийн насжилттай 0.1 сая төрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант жилд үйлдвэрчний эвлэлийн 0.1 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй.	1	0.2					1	0.2		
3		Тус байгууллага нь 2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан.	1						1			
4		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 185 нэр төрлийн 86.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	86.7							1	86.7
Дүн			4	96.1	1	9.2			2	0.2	1	86.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Хайрхан ЭМТ	31.4 сая төгрөгийн 51 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	31.4					1	31.4		
Дүн			1	31.4					1	31.4		
Нийт дүн			5	127.5	1	9.2			3	31.6	1	86.7